



БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Улаанбаатар хот

АГУУЛГА

1. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	3
1.1 Хууль эрх зүйн орчинд гарсан өөрчлөлт	3
1.2 Ерөнхий төлөв байдал.....	3
1.3 Статистик үзүүлэлтүүд	4
2. АКТИВЫН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	4
2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт	4
2.2 Зээл.....	5
2.2.1 Зээлдэгчид	6
2.2.2 Зээлийн багцын чанар	6
2.2.3 Зээлийн зориулалт	6
2.2.4 Зээлийн жигнэсэн дундаж хүү.....	7
2.3 Активын бусад үзүүлэлт	7
3. ПАССИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ӨӨРЧЛӨЛТ	7
3.1 Өр төлбөр	7
3.2 Эздийн өмч.....	8
4. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА	9
4.1 Орлого	9
4.2 Зарлага	9
4.3 Ашигт ажиллагаа.....	10
5. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	10
5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	10
5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	10
5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	11
6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД	12
6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд	12
6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд.....	14
6.3 Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-ууд.....	14
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ	15
ДҮГНЭЛТ	16

1. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Хууль эрх зүйн орчинд гарсан өөрчлөлт

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, салбарын үйл ажиллагааг дэмжих, мэргэжлийн зах зээлийг бий болгох нэгдсэн цогц бодлогын хүрээнд Хорооноос Банк бус санхүүгийн салбарын хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр 2017 онд дараах журам зааварт өөрчлөлт орууллаа.

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам заавар

2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор Банк бус санхүүгийн үйл ажиллагаа шинээр эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон 2016 оны 271 дүгээр тогтоолын заалтад өөрчлөлт оруулсантай холбогдуулан Хорооны 2016 оны 72 дугаар тогтоолыг хүчингүй болгосон.

2016 оны 72 дугаар тогтоолыг хүчингүй болгосонтой холбоотойгоор Банк бус санхүүгийн байгууллагуудыг эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан 3 ангилсан ангиллыг байхгүй болгож, 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 92, 93 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны журам”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д холбогдох өөрчлөлтийг оруулсан.

- Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг бүс нутгаас нь хамааруулан шинэчлэн тогтоож, 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор уг шийдвэр гарахаас өмнө ажиллаж байсан байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2018-2021 он хүртэлх хугацаанд үе шаттайгаар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.

1.2 Ерөнхий төлөв байдал

Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудын тоо 2017

оны жилийн эцэст 534 хүрлээ. Энэ нь 2006 оны мөн үетэй харьцуулахад 3.8 дахин, өмнөх оноос 3.09 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо



Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ 10 хувиар буурсан, хөдөө орон нутгийн ББСБ 16.7 хувиар өссөн дүнтэй байна.

Сүүлийн 5 жилийн үзүүлэлтээр ББСБ-уудын тооны өсөлт хамгийн бага буюу 3.09%-ийн өсөлттэй гарсан нь хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлагыг нэмэгдүүлсэнтэй холбоотой бөгөөд ББСБ-ууд тооноос чанарт шилжих шат руугаа явж байна.

Тайлант жилд Хорооны хуралдаанаар 31 хуулийн этгээдэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 15 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгох, 23 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 8 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг сэргээх асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл нийт 7 төрлийн 50 тусгай зөвшөөрөл олгосон бол 21 төрлийн тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон байна.

Тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын 64.52% нь давхардсан тоогоор зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оноос 4.10 хувиар, дагнан эрхэлж байгаа 360 ББСБ байгаа нь өмнөх оноос 4.96 хувиар өссөн байна. Давхардсан тоогоор гадаад валютын арилжаа эрхэлж байгаа ББСБ-уудын тоо 0.69 хувиар

өссөн бол дагнан эрхэлдэг ББСБ 3.92 хувиар буурсан байна.

Төлбөрийн баталгаа гаргах, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах болон итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нэмэгдээгүй бол факторинг болон хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээ буурсан үзүүлэлттэй гарсан байна.

1.3 Статистик үзүүлэлтүүд

2017 оны 4-р улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 534 ББСБ-аас 97% нь буюу 518 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 16 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдсан байна.

2017 онд 534 ББСБ 164 салбар нэгж, 4 төлөөлөгчийн газар, 2473 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. ББСБ-ын ажиллагсдын тоо 358-аар нэмэгдэж, 16.9 хувиар өссөн. Үүнд 5-аас дээш ажилтантай 12 ББСБ байна.

Нэр бүхий 1 ББСБ-ын цахим мөнгөний үйлчилгээний харилцагчдын тоо 1,175,964 буюу нийт харилцагчдын 84.73 хувийг дангаар бүрдүүлж байгаа нь нийт харилцагчдын тоог 148.3 хувиар өсөхөд нөлөөлжээ.

2017 оны байдлаар ББСБ-уудын хувьцаа эзэмшигчээр 1039 иргэн болон хуулийн этгээд бүртгэлтэй байна.

2017 оны байдлаар 534 ББСБ-ын 10.4% буюу 56 ББСБ 164 салбар нэгжтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнд 10-аас дээш салбартай 4 ББСБ, 5-9 салбартай 6 ББСБ байгаа нь нийт салбартай ББСБ-уудын 58.54 хувийг бүрдүүлж байна.

Салбар нэгжүүдийг байршлаар нь харвал хөдөө орон нутагт 50 салбар, Улаанбаатар хотод 114 салбар байна. Салбар нэгжийн тоо

тайлант жилд 40 буюу 32.26 хувиар өссөн дүнтэй гарчээ.

Хүснэгт 1 Ерөнхий статистик үзүүлэлт 2 /тэрбум.төг/


Үзүүлэлтүүд	2016	2017	Өөрчлөлт	
	дүн	дүн	дүн	хувь
Нийт хөрөнгө	787.2	969.2	182.0	23.12%
Банкны салбартай харьцуулахад /хувиар/	3.10%	3.37%		0.27%
Нийт зээлийн өрийн үлдэгдэл	478.2	638.0	159.8	33.43%
Банкны салбартай харьцуулахад /хувиар/	3.90%	4.79%		0.89%
Нийт өөрийн хөрөнгө	578.5	758.2	179.7	31.06%
Банкны салбартай харьцуулахад /хувиар/	18.60%	22.76%		4.16%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	440.6	595.4		154.8
Нийт орлого	193.4	195.9		2.5
Нийт зарлага	134.4	129.1		(5.3)
Цэвэр ашиг/алдагдал	59.0	66.8		7.8

Улсын хэмжээнд нийт 534 ББСБ байгаа бөгөөд Улаанбаатар хотод банк бус санхүүгийн байгууллагуудын 86.9% буюу 464 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна. Үүний 65.95% нь Чингэлтэй болон Сүхбаатар дүүргүүдэд үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Багахангай дүүрэгт ББСБ-ын төв болон салбарын аль аль нь бүртгэлгүй байна.

2017 онд тусгай зөвшөөрөл авсан 31 ББСБ-ын 10 нь хөдөө орон нутагт байрлалтай байна.

Нийт ББСБ-уудын 273 ББСБ санхүүгийн программ ашиглаж байгаа бол 261 ББСБ санхүүгийн программгүй үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 2 Программ ашиглалт



Үүнээс хамгийн нийтлэг нь ашиглаж байгаа санхүүгийн программ нь “Ай Би Ай” ХХК-ийн Спинел болон Даймонд программ, “Грейпсити” ХХК-ийн Ачидбанкир болон MARS програмууд байна.

2. АКТИВЫН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт

2017 оны байдлаар ББСБ-уудын нийт активын бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 2 Активын бүтэц /мян.төг/

ХӨРӨНГӨ	2016		2017		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	754,283,187.50	95.8%	932,691,578.16	96.24%	178,408,390.66	23.65%
Мөнгөн хөрөнгө	243,107,520.28	30.9%	264,057,750.71	27.25%	20,950,230.43	8.62%
БХХО-лт /цэврээр/	1,302,735.20	0.2%	2,742,652.53	0.28%	1,439,917.33	110.53%
Нийт зээл	478,175,223.30	60.7%	638,007,828.51	65.83%	159,832,605.21	33.43%
(Зээлийн эрсдэлийн сан)	(42,065,155.73)	(5.3%)	(56,005,828.97)	(5.78%)	(13,940,673.24)	33.14%
Нийт факторингийн тооцооны авлага	37,795.00	0.0%	125,000.00	0.01%	87,205.00	230.73%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	(30,000.00)	0.0%	-	0.00%	30,000.00	100.00%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	4,480,032.56	0.6%	8,110,651.51	0.84%	3,630,618.95	81.04%
Бусад хөрөнгө	69,275,036.88	8.8%	75,653,523.87	7.81%	6,378,486.99	9.21%
Эргэлтийн бус хөрөнгө	32,888,822.60	4.2%	36,487,417.42	3.76%	3,598,594.82	10.94%
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	40,100,706.81	5.1%	45,465,742.73	4.69%	5,365,035.92	13.38%
(Хуримтлагдсан элэгдэл)	7,211,884.21	0.9%	8,978,325.31	0.93%	1,766,441.10	24.49%
НИЙТ ХӨРӨНГӨ	787,172,010.10	100.0%	969,178,995.57	100.00%	182,006,985.47	23.12%

Нийт активын 93.08 хувийг буюу эргэлтийн хөрөнгийн ихэнх хэсгийг мөнгөн хөрөнгө болон нийт зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Активын гол өөрчлөлтүүдийг харвал нийт зээлийн үлдэгдэл 159.8 тэрбум буюу өмнөх оноос 33.43 хувиар өссөн дүнтэй гарсан бол мөнгөн хөрөнгө 8.62% буюу 20.9 тэрбум төгрөгөөр өсжээ.

- Мөнгөн хөрөнгө

Нийт активын 27.25% буюу 264.0 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө байна. Үүнээс 144.6 тэрбум төгрөг буюу мөнгөн хөрөнгийн 54.77% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 76.45 тэрбум буюу 28.95% нь банк болон санхүүгийн байгууллагын харилцах дансанд, 16.28% буюу 43.0 тэрбум нь хадгаламжид байршиж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэлэн мөнгө 40.31 хувиар, хадгаламж хэлбэрээр 3.68 хувиар өссөн бол харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө 22.44 хувиар буурсан байна.

- Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт өмнөх онтой харьцуулахад 2.1 дахин өссөн байна.

Тайлант улиралд 25 ББСБ богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгсэлд 2.7 тэрбум төгрөг байршуулснаас 1.5 тэрбум төгрөгийг 8 ББСБ-ын Засгийн газрын үнэт цаасанд хийсэн хөрөнгө оруулалт, 15 ББСБ-ын 1.2 тэрбум төгрөгийн хувьцаагаарх хөрөнгө оруулалт, 2

ББСБ-ын 33.0 сая төгрөгийн бусад богино хугацаат хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх сонирхол бий болсонтой холбоотойгоор арилжааны үнэт цаас 6.2 дахин, хөрөнгө оруулалтын үнэт цаас 1.6 дахин нэмэгдсэн хэдий ч богино хугацаат хөрөнгө оруулалт нь нийт активын 0.28 хувийг бүрдүүлж байна. Засгийн газрын үнэт цаасанд 68-800 сая хүртэлх төгрөгийг байршуулсны 54 хувийг нэг компанийн хөрөнгө оруулалт дангаараа бүрдүүлж байгаа бол хувьцаагаарх хөрөнгө оруулалтад 1.0-1,155.0 сая төгрөг хүртэлх төгрөг байршуулсны 93.4 хувийг нэг компанийн хувьцаагаарх хөрөнгө оруулалт дангаараа бүрдүүлж байна.

Хүснэгт 3 Нийт актив интервалаар /мян.төг/

Интервал	ББСБ тоо	Дүн	Эзлэх хувь
1 тэрбумаас доош	263	147,292,639.46	15.20%
1-4.9 тэрбум хүртэл	241	442,268,162.58	45.63%
5 тэрбум ба түүнээс дээш	30	379,618,193.54	39.17%
НИЙТ	534	969,178,995.58	100%

Нэгтгэлийн дүнгээрх активын төвлөрлийг харвал 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 241 ББСБ нийт активын 45.63 хувийг, 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 30 ББСБ нийт активын 39.17 хувийг бүрдүүлж байна.

2.2 Зээл

2017 оны байдлаар 482 ББСБ нь 638.0 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй, 107,442

зээлдэгчтэй үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ нь нийт активын 65.83%, эргэлтийн хөрөнгийн 68.41 хувийг бүрдүүлж байна.

2.2.1 Зээлдэгчид

Зээлдэгчдийн тоо 4485-аар буюу 4.36 хувиар өсжээ. 2016 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад хэвийн зээлдэгчдийн тоо 2294, хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн тоо 1180, чанаргүй зээлдэгчдийн тоо 1011-ээр нэмэгджээ.

Хүснэгт 4 Ерөнхий статистик 3

ХАРИЛЦАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ	ДҮН	ХУВИАР
Нийт харилцагчдын тоо /оны эхнээс өссөн дүнгээр/	1,387,894.00	100%
Үүнээс: Эмэгтэй	117,572.00	8.47%
Хуулийн этгээд	3,330.00	0.24%
Зээлдэгчдийн тоо	107,442.00	100%
Хэвийн	96,967.00	90.25%
Хугацаа хэтэрсэн	4,187.00	3.90%
Чанаргүй:	6,288.00	5.85%
Хэвийн бус	1,321.00	1.23%
Эргэлзээтэй	1,170.00	1.09%
Муу	3,797.00	3.53%
Зээлдэгчдийн насжилт /тоогоор/	106,311.00	100%
18-35 насны	49,792.00	46.84%
36-45 насны	34,003.00	31.98%
46-55 насны	17,362.00	16.33%
55-аас дээш	5,154.00	4.85%
Зээлдэгчдийн боловсрол /тоогоор/	106,303.00	100%
Дээд	58,497.00	55.03%
Тусгай дунд	16,680.00	15.69%
Бүрэн дунд	23,667.00	22.26%
Дунд	2,906.00	2.73%
Бага	4,553.00	4.28%

2.2.2 Зээлийн багцын чанар

Хүснэгт 5 Зээлийн чанар /тэрбум.төг/

Ангилал	2016		2017		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Хэвийн	392.0	34.44%	527.0	35.0	35.0	34.44%
Хугацаа хэтэрсэн	26.7	12.05%	29.9	3.2	3.2	12.05%
Чанаргүй зээл:	59.5	36.35%	81.1	21.1	21.1	36.35%
Хэвийн бус	12.8	37.51%	17.6	4.8	4.8	37.51%
Эргэлзээтэй	18.2	21.63%	14.2	(3.9)	(3.9)	21.63%
Муу	28.5	72.73%	49.3	20.8	20.8	72.73%
(Зээлийн эрсдэлийн сан)	(42.1)		(56.0)	(13.9)	(13.9)	33.14%
Нийт зээл	478.2	33.4%	638.0	159.8	159.8	33.4%
Үүнээс:						
Төгрөгийн	434.8	39.20%	605.3	170.5	170.5	39.20%
Гадаад валютын	43.4	(24.53%)	32.7	(10.6)	(10.6)	(24.53%)

Зээлийн эрсдэлийн санд хуримтлуулсан хөрөнгийн хэмжээ чанаргүй зээлийн 64.5 хувьтай тэнцэж байна.

Сүүлийн таван жилийн дүн мэдээнээс харахад нийт зээлд эзлэх хэвийн болон хугацаа

хэтэрсэн зээлийн хэмжээ буурч зээлийн хэмжээ муу зээлийн хэмжээ өссөн байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар зээлийн өрийн үлдэгдлийн 82.6 хувь нь хэвийн зээл, 4.7 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 12.7 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна.

10 тэрбумаас дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй 12 ББСБ нийт зээлийн өрийн үлдэгдлийн 31 хувийг бүрдүүлж байна.


2.2.3 Зээлийн зориулалт

2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 681.8 тэрбум төгрөгийн зээл олгож үүнээс 519.7 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж нийт зээлийн өрийн үлдэгдэл 638.0 тэрбум төгрөг байна. /өмнөх оны зээлийн өрийн үлдэгдэл 478.2 тэрбум/

Нийт зээлийн үлдэгдлийн 509.3 тэрбум төгрөг буюу 79.82 хувийг иргэдэд, 128.7 тэрбум төгрөг буюу 9.76 хувийг хувийн хэвшилд олгосон зээл бүрдүүлж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл:

Зураг 3 Олгосон болон төлөгдсөн зээл /хувиар/



Иргэдэд олгосон болон төлөгдсөн зээлийг авч үзвэл хэрэглээний зээл 264.6 тэрбум төгрөгийг олгож, 196.8 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн, бөөний болон жижиглэнгийн худалдааны зээл 151.6 тэрбум төгрөгийг олгож, 120.6 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн байна.

Хувийн хэвшилд олгосон болон төлөгдсөн зээлийг авч үзвэл хэрэглээний зээл 22.9 тэрбум төгрөгийг олгож 26.5 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн, барилгын зориулалтаар 20.3 тэрбум төгрөгийн олгож, 20.9 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн байна.

2.2.4 Зээлийн жигнэсэн дундаж хүү

2017 оны жилийн эцсийн байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 482 ББСБ байгаа ба олгосон зээлийн дээд хүү нь 10%, доод хүү нь 1.16%, жигнэсэн дундаж хүү 3.37% байна. ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж хүү 3.37%-тай гарсан нь 2016 онтой харьцуулахад 0.63 пунктээр буусан үзүүлэлт юм. Банкны салбартай харьцуулахад жигнэсэн дундаж хүү 1.8 пунктээр өндөр гарсан байна.

2.3 Активын бусад үзүүлэлт

Факторингийн тооцооны авлага 3.3 дахин, өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө 1.8 дахин, бусад хөрөнгө 6.4 тэрбум төгрөгөөр өсөж факторингийн авлагын эрсдэлийн сан 100% буурчээ.

2017 оны жилийн эцсийн байдлаар факторингийн тооцооны авлага 125 сая төгрөгийн хэвийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 534 ББСБ-ын 45.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөнд 8.9 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байна.

3. ПАССИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ӨӨРЧЛӨЛТ

Салбарын нийт хөрөнгийн 211 тэрбум буюу 21.77 хувийг бусдаас татсан эх үүсвэр, 78.23 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байгаагийн 61.43 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 16.0 хувийг хуримтлагдсан ашиг, 11.63 хувийг банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, 4.05 хувийг итгэлцлийн үйлчилгээний өглөг, 6.89 хувийг бусад эх үүсвэр бүрдүүлж байна.

Хүснэгт 6 Пассивын бүтэц /сая.төг/

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2016		2017		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<i>Өр төлбөр</i>	208,680,807.35	26.51%	211,011,111.68	21.77%	2,330,304.33	1.12%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	30,461,357.62	3.87%	39,217,724.91	4.05%	8,756,367.29	28.75%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	121,417,969.09	15.42%	112,761,691.28	11.63%	(8,656,277.81)	(7.13%)
Бусад эх үүсвэр	4,118,667.72	0.52%	6,711,180.46	0.69%	2,592,512.74	62.95%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	4,080,000.46	0.52%	6,876,904.69	0.71%	2,796,904.23	68.55%
Төслийн зээлийн санхүүжилт	21,386,989.05	2.72%	14,869,904.02	1.53%	(6,517,085.03)	(30.47%)
Бусад өр төлбөр	27,215,823.42	3.46%	30,573,706.32	3.15%	3,357,882.90	12.34%
<i>Эздийн өмч</i>	578,491,202.75	73.49%	758,167,883.90	78.23%	179,676,681.15	31.06%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	440,547,491.22	55.97%	595,389,138.10	61.43%	154,841,646.88	35.15%
Бусад өмч	6,087,084.37	0.77%	6,570,783.12	0.68%	483,698.76	7.95%
Сангууд	461,368.17	0.06%	429,638.93	0.04%	(31,729.24)	(6.88%)
Хуримтлагдсан ашиг/алдагдал	130,396,503.22	16.57%	155,071,768.46	16.00%	24,675,265.25	18.92%
Хоёрдогч өглөг	998,755.78	0.13%	706,555.28	0.07%	(292,200.50)	(29.26%)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	787,172,010.10	100%	969,178,995.58	100%	182,006,985.48	23.12%

3.1 Өр төлбөр

ББСБ-ын өр төлбөрийн хэмжээ 2017 онд 1.12 хувиар өсөж 211.0 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгөнд эзлэх хувь хэмжээ 21.8% болж, 4.7 пунктээр буурлаа. Өр төлбөрийн 1.12 хувийн өсөлтөд итгэлцлийн үйлчилгээний өглөг 8.8

тэрбум, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 3.7 тэрбум, төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 3.1 тэрбум, ББСБ-аас гаргасан өрийн бичиг 6.9 тэрбум төгрөгт хүрсэн нь нөлөөлөв.

Нийт хөрөнгөнд эзлэх өр төлбөрийн хувь хэмжээний бууралтад дотоод гадаад банк санхүүгийн байгууллагуудад төлөх төлбөр 7.13 хувиар буурсан, төслийн зээлийн санхүүжилт 30.47 хувиар буурсан нь нөлөөлжээ.

- Итгэлцлийн үйлчилгээний өглөг

Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 28 ББСБ-ын 22 нь 2017 онд 39.2 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн нь салбарын нийт өр төлбөрийн 18.59 хувьтай тэнцэж байгаа ба итгэлцлийн үйлчилгээнээс орлого олоогүй байна.

- Дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2017 оны байдлаар 67 ББСБ дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан 112.8 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт хөрөнгийн 11.63 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оноос 8.7 тэрбум төгрөгөөр буюу 7.13 хувиар буурсан үзүүлэлт юм.

Нийт өр төлбөрийн 53.44 хувийг бүрдүүлж байгаа банк санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн 65.53 хувийг дотоодын, 34.47 хувийг гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл эзэлж байна.

Дотоодын банк санхүүгийн байгууллагуудаас 63 ББСБ 73.9 тэрбум төгрөг, гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас 9 ББСБ 38.9 тэрбум төгрөгийн зээл татан төвлөрүүлсэн байна.

- Бусад эх үүсвэр

Бусад эх үүсвэр нийт хөрөнгийн 0.69 хувийг бүрдүүлж байгаа ба өмнөх оноос 62.95 хувиар буюу 2.6 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ.

- ББСБ-аас гаргасан өрийн бичиг

2017 оны байдлаар 8 ББСБ 6.9 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргасан нь өмнөх оноос 68.55 хувиар өссөн дүн байна.

- Төслийн зээл санхүүжилт

2017 онд 35 ББСБ 14.9 тэрбум төгрөгийн төслийн зээлтэй байгаа нь нийт хөрөнгийн 1.53 хувийг эзэлж байгаа ба өмнөх оноос 6.5 тэрбум төгрөг буюу 30.47 хувиар буурчээ.

Төслийн санхүүжилтийн 54.48% буюу 8.1 тэрбум төгрөгийг төгрөгийн, 45.52% буюу 6.8 тэрбум төгрөгийг валютын зээл эзэлж байна.

Богино хугацаат санхүүжилтээр 11 ББСБ 2.9 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байгаа бол урт хугацаат санхүүжилтээр 26 ББСБ 11.9 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан байна.

Төслийн зээлийн 8.3 тэрбум төгрөгийг гадаад байгууллагаас, 4.1 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагаас, 684.0 сая төгрөгийг Засгийн газрын төслийн зээлийн эх үүсвэрээс 1.8 тэрбум төгрөгийг бусад санхүүжилтээс бүрдүүлсэн байна.

3.2 Эздийн өмч

Сүүлийн 5 жилийн байдлаар нийт ББСБ-уудын өр төлбөр нийт хөрөнгийн хэмжээнд эзлэх хувь хэмжээ буурсан бөгөөд энэ нь ББСБ-ууд өөрийн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлж байгаатай холбоотой. ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хэмжээ 2016 оны жилийн эцэст 56.0 хувийг бүрдүүлж байсан бол энэ онд 61.4 хувийг бүрдүүлж байна.

2017 оны байдлаар 2.5 тэрбум ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 55 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 36.5 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 0.8-0.9 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-ууд 29.94 хувийг эзэлж байна. 0.7 тэрбумаас доош хөрөнгөтэй 119 ББСБ байгаа ба үүнд хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 70 ББСБ болон гадаад валютын үйл ажиллагаа дагнан эрхэлдэг 49 ББСБ-уудын 17.8 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.0 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 7 Хувь нийлүүлсэн хөрөнгө /интервалаар/

Интервал	ББСБ тоо	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
0.7 тэрбумаас доош	119	22.28%	17.9	3.00%
0.8-0.9 тэрбум хүртэл	220	41.20%	178.3	29.94%

1-1.3 тэрбум хүртэл	97	18.16%	103.0	17.30%
1.4-1.8 тэрбум хүртэл	21	3.93%	33.0	5.54%
1.9-2.4 тэрбум хүртэл	22	4.12%	46.0	7.72%
2.5-4.9 тэрбум хүртэл	43	8.05%	128.2	21.52%
5 тэрбум ба түүнээс дээш	12	2.25%	89.2	14.98%
НИЙТ	534	100.00%	595.4	100%

Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2.5 тэрбум байхаар шинэчлэн тогтоож 2021 он хүртэл үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээ авч, хангалтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлж ББСБ-уудын эрсдэл даах чадварыг сайжруулах, мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, улмаар санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ үйлчилгээний өртгийг бууруулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

4. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

2017 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 195.9 тэрбум төгрөгийн орлоготой, 129.1 тэрбум төгрөгийн зарлагатай 66.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай гарлаа.

4.1 Орлого

2017 оны байдлаар ББСБ-уудын нийт орлого 1.27 хувиар өссөн дүнтэй гарчээ. Хүүгийн орлого 26.3 тэрбум төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны орлого 3.2 тэрбум төгрөгөөр өссөн бол хүүгийн бус орлого 27.1 тэрбум төгрөгөөр буурсан дүнтэй гарчээ.

- Хүүгийн орлого

Хүүгийн орлогын хэмжээ өмнөх оноос 19.4 хувиар буюу 26.3 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарч нийт орлогын хэмжээг 2.5 тэрбум төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

466 ББСБ 161.9 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон байна.

Хүүгийн орлогыг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн 452 ББСБ-ын 154.8 тэрбум төгрөгийн орлого, хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн 179 ББСБ-ын 6.0 тэрбум төгрөгийн орлого, үнэт цаасны хүүгийн 10 ББСБ-ын 363.8 сая төгрөгийн орлого, бусад хүүгийн 682.9 тэрбум төгрөгийн орлого, бүрдүүлж байна.

- Хүүгийн бус орлого

Хүүгийн бус орлого нь 2017 оны байдлаар нийт орлогын 13.92 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оноос 49.83 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд үүнд гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого өмнөх оноос 69.63% буюу 27.7 тэрбум төгрөгөөр, санхүүгийн зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээний орлого 96.67% буюу 3.9 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

260 ББСБ-ын хүүгийн бус орлого 23.0 тэрбум төгрөгөөр буурсан, 240 ББСБ-ын хүүгийн бус орлого 50.0 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт гарчээ.

- Үндсэн бус үйл ажиллагааны орлого

Үндсэн бус үйл ажиллагааны орлого нийт орлогын 3.4 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд 2016 онтой харьцуулахад 3.2 тэрбум төгрөгийн буюу 93.2 хувийн өсөлттэй байна.

4.2 Зарлага

2017 онд 515 ББСБ 129.1 тэрбум төгрөгийн зардалтай гарсан нь 2016 онтой харьцуулахад 3.94 хувиар буурсан үзүүлэлт байна.

Хүүгийн болон хүүгийн бус зардал буурсан үзүүлэлттэй гарсан бол бусад зардал өссөн дүнтэй гарчээ.

- Хүүгийн зардал

Хүүгийн зардал нийт зардлын 11.03% буюу 14.2 тэрбум төгрөг байна. 2016 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад 7.37 хувиар буурсан дүн юм. Үүнд банкнаас авсан зээлийн хүүгийн зардал 1.4 тэрбум төгрөгөөр буюу 28.31 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

- Хүүгийн бус зардал

Хүүгийн бус зардал нь 79.2 тэрбум буюу нийт зардлын 61.38 хувийг бүрдүүлж байна. 2017 онд 9.7 тэрбум төгрөг буюу 10.9 хувиар буурсан ба үүнд гадаад валютын арилжааны зардал 65.28 хувиар буюу 20.9 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

- Болзошгүй эрсдэлийн зардал

Нийт зардлын 18.88% буюу 24.4 тэрбум төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал бүрдүүлж байгаа ба энэ зардал нь өмнөх оноос

15 хувиар буюу 3.2 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарсан байна.

- Үндсэн бус үйл ажиллагааны зардал

Нийт зардлын 1.70 хувийг үндсэн бус үйл ажиллагааны зардал бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс 17.09 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.

4.3 Ашигт ажиллагаа

2017 онд ББСБ-ууд 66.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 7.8 тэрбум төгрөгөөр буюу 13.2 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа.

534 ББСБ-ын 444 нь буюу 83.15% нь 77.7 тэрбум төгрөгийн ашигтай, 71 нь буюу 13.30% нь 10.9 тэрбум төгрөгийн алдагдалтай, 19 нь буюу 3.56% нь үйл ажиллагаа эрхлээгүй байна.

5. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 534 ББСБ-ын 84.64% буюу 452 ББСБ үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 15.36% нь буюу 82 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 60 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 14 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 5 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 5 ба түүнээс дээш зохистой харьцаа алдагдсан 2 ББСБ байна.

5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 8 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	38	73.08%
1 зохистой харьцааг хангаагүй	10	19.23%
2 зохистой харьцааг хангаагүй	4	7.69%
3 зохистой харьцааг хангаагүй	-	-

4 зохистой харьцааг хангаагүй	-	-
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	-	-
НИЙТ	52	100%

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 49 ББСБ хангасан буюу биелэлт 94.23%;
2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 92.31%;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага 51 ББСБ хангасан буюу биелэлт 98.08%;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 44 ББСБ хангасан буюу биелэлт 84.62%;
5. Үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлагыг 50 ББСБ хангасан буюу 96.15%;
6. Өөрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Эдгээр 53 ББСБ-уудын хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хамгийн ихээр алдагдсан байна.

5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 14 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 9 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	372	85.91%
1 зохистой харьцааг хангаагүй	45	10.39%
2 зохистой харьцааг хангаагүй	10	2.31%
3 зохистой харьцааг хангаагүй	4	0.92%
4 зохистой харьцааг хангаагүй	1	0.23%
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	1	0.23%
НИЙТ	433	100%

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 425 ББСБ хангасан буюу биелэлт 98.15%;
2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 425 ББСБ хангасан буюу биелэлт 98.15%;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 431 ББСБ хангасан буюу биелэлт 99.5%;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 421 ББСБ хангасан буюу биелэлт 97.23 хувь;
5. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний зөрүү 0 байх шаардлагыг 432 ББСБ хангасан буюу биелэлт 99.77%;
6. Нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 420 ББСБ хангасан буюу биелэлт 97.0%;
7. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн хэмжээ 10 хувиас ихгүй байх шаардлагыг 426 ББСБ хангасан буюу биелэлт 98.38%;
8. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлагыг 429 ББСБ хангасан буюу биелэлт 99.08%;
9. Үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас ихгүй байх шаардлагыг 432 ББСБ хангасан буюу биелэлт 99.77 хувь;
10. Нэг компаниас худалдан авах үнэт цаасны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
11. ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
12. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлага 416 ББСБ хангасан буюу биелэлт 96.07%;
13. Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг 420 ББСБ хангасан буюу биелэлт 97.0% хувь;
14. Өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй байх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх 433 хуулийн этгээдийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт, гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа, цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлтүүдийг 12-17 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Хүснэгт 10 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	42	85.71%
1 зохистой харьцааг хангаагүй	5	10.20%
2 зохистой харьцааг хангаагүй	-	-
3 зохистой харьцааг хангаагүй	1	2.04%
4 зохистой харьцааг хангаагүй	-	-
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	1	2.04%
НИЙТ	49	100%

Журмын 3.4-т заасан хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих 18 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 97.96%;
2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 97.96%;

3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 97.96%;
 4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 95.92%;
 5. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг 48 ББСБ хангасан буюу биелэлт 97.96%;
 6. Нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 97.96%;
 7. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 10 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 97.96% ;
 8. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
 9. Үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 50 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 97.96%;
 10. Худалдан авах хувьцааны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 97.96%;
 11. Нэг компаниас худалдан авах хувьцааны төвлөрлийн үзүүлэлт өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
 12. Өрийн бичгийн эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
 13. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 97.96%;
 14. ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлагыг бүрэн;
 15. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 95.92%;
 16. Итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн зохистой харьцаа 80 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 97.96%;
 17. Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 95.92%;
 18. Өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй айх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.
- Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх 49 хуулийн этгээдийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа, цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлтүүдийг 1-2 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд

Тайлант онд хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 70 ББСБ, 179 хувьцаа эзэмшигч, 167 ажилтан, 5 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 8383 харилцагч, 5591 зээлдэгчдэд хүрч ажиллаж байна.

Хамгийн олон ББСБ-тай аймгууд нь Төв аймаг 8, Орхон аймаг 7, Дорнод, Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад тус тус 6 ББСБ байршиж байна.

Зураг 4 Орон нутгийн ББСБ-ууд, орон нутаг дахь салбаруудын тархалт



ББСБ-ын 5 төрлийн 78 тусгай зөвшөөрлийн хүрээнд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. 26 ББСБ буюу 37.1% нь санхүүгийн программтай байна.

2017 оны байдлаар орон нутгийн 70 ББСБ нь нийт ББСБ-уудын 13.11 хувийг эзэлж байна. ББСБ-уудын тоо 10-аар нэмэгдсэн ба өмнөх онуудтай харьцуулахад өсөлтийн хурд 16.67% болж буурчээ.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт зээлдэгчдийн 91.16% нь хэвийн, 3.11% нь хугацаа хэтэрсэн, 5.72% нь чанаргүй зээлдэгчид байна.

ББСБ-уудын насжилтаар авч үзвэл орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт зээлдэгчдийн 75.5 хувийг 18-45 насны, 17.75 хувийг 46-55 насны, 6.73 хувийг 55-аас дээш насны иргэд эзэлж байна. Боловсролын түвшний хувьд дээд боловсролтой иргэд 45.12%, тусгай дунд болон бүрэн дунд боловсролтой иргэд 46.04%, бага болон дунд боловсролтой иргэд 8.84 хувийг бүрдүүлж байна.

• **Актив**


Салбарын нийт активын 2.27 хувийг бүрдүүлж байгаа орон нутгийн ББСБ-уудын 21.96 тэрбум төгрөгийн актив хөрөнгийн 14.1

тэрбум нь зээл, 5.9 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө 1.9 тэрбум төгрөгийг бусад хөрөнгө бүрдүүлж байна.

Мөнгөн хөрөнгийг бүтцээр авч үзвэл 64 ББСБ-ын 3.3 тэрбум төгрөгийн бэлэн мөнгө, 55 ББСБ-ын 2.1 тэрбум төгрөгийн харилцахад байршуулсан мөнгө, 4 ББСБ-ын 535.9 сая төгрөгийн хадгаламжид байршуулсан мөнгөн хөрөнгө байна.

Зээлийн хувьд 13.46 тэрбум төгрөгийн хэвийн зээл, 268.28 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 5.0 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Зээлийн эрсдэлийн санг чанаргүй зээлийн 92.6 хувьд байгуулжээ.

Зураг 5 Орон нутгийн ББСБ-уудын зээлийн бүтэц



2017 онд орон нутгийн банк санхүүгийн байгууллагын үндсэн ба биет бус хөрөнгө

цэврээр 829.89 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

- **Пассив**

Орон нутгийн 70 ББСБ-ын хөрөнгө 21.9 тэрбум төгрөгийн 91.27% буюу 20.0 тэрбум төгрөг нь эздийн өмч, 8.73% буюу 1.9 тэрбум төгрөг нь өр төлбөр байна. Орон нутгийн ББСБ-уудын нийт хөрөнгийн 84.85 хувийг буюу 18.6 тэрбум төгрөгийг хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдүүлж байгаа ба энэ нь салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.13 хувьтай тэнцэж байна

- **Орлого үр дүнгийн тайлан**

2017 онд орон нутгийн ББСБ-ууд 4.8 тэрбум төгрөгийн орлоготой, 4.1 тэрбум төгрөгийн зарлагатай, 676.8 сая төгрөгийн цэвэр орлоготой ажиллаа. Орлогын 90.4 хувийг хугацаандаа байгаа хүүгийн орлого бүрдүүлж байна. Нийт зардлын 46.66% буюу 1.9 тэрбум төгрөгийг хүүгийн бус зардал /үүнээс боловсон хүчний холбогдолтой зардал 1.1 тэрбум, бусад зардал 815 сая/, 45.08% буюу 1.9 тэрбум төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал /үүнээс зээлийн эрсдэлийн зардал 1.8 тэрбум/ эзэлж байна.

6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд

- **Ерөнхий статистик**

Тайлант улиралд гадаадын хөрөнгө оруулалттай 11 улсын 27 ББСБ, 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 62 хувь нийлүүлэгч 8 төрлийн 51 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа нь салбарын ББСБ-ын тооны 5.06 хувийг эзэлж байна.

- **Актив**

Гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ-ын хөрөнгө 135.3 тэрбум төгрөг нь нийт хөрөнгийн 13.96 хувийг бүрдүүлж байна.

Активын 63.67% зээл, 23.90% нь мөнгөн хөрөнгө байгаа бол мөнгөн хөрөнгийн 13.29% буюу 4.2 тэрбум төгрөг нь кассанд, 38.59% буюу 12.1 тэрбум төгрөг нь харилцах дансанд, 48.12% буюу 15.1 тэрбум төгрөг нь хадгаламжийн дансанд тус тус байршиж байна.

- **Пассив**

Пассивын 50.2% буюу 67.9 тэрбум төгрөгийг өр төлбөр, 49.8% буюу 57.4 тэрбум төгрөгийг эздийн өмч эзэлж байна.

Нийт 534 ББСБ-ын пассивын бүтэц нь эздийн өмч давамгайлсан бүтэцтэй байдаг бол гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын хувьд өр төлбөр болон эздийн өмчийн харьцаа ойролцоо дүнтэй байна. Өр төлбөрийн 66.0% нь дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээл байгаа бол эздийн өмчийн 81.9% нь хувь нийлүүлсэн хөрөнгө байна.

Дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн 42.8% буюу 19.2 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагуудаас, 57.2% буюу 25.6 тэрбум төгрөгийг гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас авсан өр төлбөр эзэлж байна.

- **Орлого үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаанд гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын 26 нь 36.0 тэрбум төгрөгийн орлоготой, 28.8 тэрбум төгрөгийн зарлагатай, 7.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

6.3 Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-ууд

- **Ерөнхий статистик**

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлж байгаа ББСБ нь нийт ББСБ-уудын 9%, гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ-уудын 34% буюу 49 ББСБ, 6 салбар, 166 ажилтан, 83,205 харилцагчдад хүрч үйл ажиллагаа эрхэлж байна.

Гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 145 ББСБ байгаагаас дагнан эрхэлж байгаа 49 ББСБ-уудын 47 нь Улаанбаатар хотод, 2 ББСБ орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

- **Актив**


Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын нийт активын хэмжээ 9.56 тэрбум төгрөг байгаа нь салбарын активын 0.99% байна. Нийт активын 96.7% нь мөнгөн

хөрөнгө, 0.01% нь богино хугацаат хөрөнгө оруулалт байна.

- Пассив

Нийт хөрөнгийн 88.6% буюу 8.5 тэрбум төгрөг нь хувь нийлүүлсэн хөрөнгө, 10.1% буюу 963.5 тэрбум төгрөг нь хуримтлагдсан ашиг байна.

Зураг 6 Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгө /интервал/



- Орлого үр дүнгийн тайлан

Тайлант хугацаанд 1.5 тэрбум төгрөгийн орлоготой, 1.2 тэрбум төгрөгийн зарлагатай, 264.7 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.


36 ББСБ 358.1 сая төгрөгийн орлоготой, 12 ББСБ 93.4 сая төгрөгийн алдагдалтай, 1 ББСБ үйл ажиллагаа явуулаагүй байна.

Орлогын бүтцийн 96.76% нь гадаад валютын арилжааны орлого, 1.9% нь гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлогоос бүрдэж байгаа бол зарлагын бүтцийн хувьд 58.7% нь боловсон хүчний холбогдолтой зардал, 30.7% нь бусад зардал, 4.5% нь арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал байна.

- Гадаад валютын арилжааны дүн мэдээ

Хорооны гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 145 ББСБ-уудын 2017 оны 1 сараас 12 сар хүртэлх арилжааны дүн мэдээгээр 1,034.6 тэрбум төгрөгийн гадаад валют худалдан авч 1,035.8 тэрбум төгрөгийн гадаад валют зарсан байна.

Зураг 7 Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын арилжааны дүн /2017 он, сараар/



ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

- Зохицуулалтын үйлчилгээний хөлс: 2017 онд нийт 451 ББСБ-аас 721,922.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 448 ББСБ 716,632.0 мянган төгрөгийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн буюу биелэлт 99 хувьтай байна.
- Зээлийн мэдээллийн сан: Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүргийг тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 482 ББСБ-ын 84% буюу 406 ББСБ хэрэгжүүлж ажилласан байна.
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх: Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх үүргийг тайлант улиралд 534 ББСБ-ын 80 хувь буюу 427 ББСБ хэрэгжүүлсэн байх тул Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15.4 дэх хэсгийн “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулан дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.
- 20 сая төгрөгөөс дээш гүйлгээг мэдээлэх: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд нэр бүхий 2 ББСБ 22 удаагийн тохиолдлоор 2.4 тэрбум төгрөгийн сэжигтэй гүйлгээ, 100 ББСБ 11,595 удаагийн тохиолдлоор 511,3 тэрбум төгрөгийн 20 сая төгрөг, түүнээс дээш

үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

2017 оны тайлант жилд Хорооны ББСБ-ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа 534 ББСБ-ын 97% буюу 518 ББСБ санхүүгийн тайлан мэдээгээ бүрэн ирүүлсэн байна. 4 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр, 12 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр 2017 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдлаа.

ББСБ-уудын төвлөрлөөр авч үзвэл 464 ББСБ Улаанбаатар хотод, 70 ББСБ хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

Үйл ажиллагааны төрлөөр үзвэл Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.6-7.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд 52, 7.1.1-7.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд 433, 7.1.17.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд 49 байгаа ба 534 ББСБ нийт 1,471,099 харилцагч, 107,442 зээлдэгчдэд хүрч ажилласан нь өмнөх онтой харьцуулахад харилцагчдын тоо 1.5 дахин, зээлдэгчдийн тоо 61.69 хувиар, ББСБ-ын тоо 3.09 хувиар өссөн үзүүлэлт юм.

ББСБ-уудын нийт актив 969.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 182.0 тэрбум төгрөгөөр буюу 23.12 хувиар өссөн байна. Энэ нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.37 хувьтай тэнцэж байгаа нь өмнөх оноос 0.27 хувиар өсжээ. ББСБ-уудын активын төвлөрлийг харвал 1.0 тэрбумаас доош хөрөнгөтэй 263 ББСБ нийт активын 15.2 хувийг, 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 241 ББСБ, 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 30 ББСБ байгаа буюу эдгээр 271 ББСБ нь нийт активын 84.8 хувийг бүрдүүлж байна.

Нийт зээлийн үлдэгдлийн хэмжээ 159.8 тэрбум төгрөгөөр буюу 33.41 хувиар өссөн ч үүнтэй зэрэгцэн зээлийн эрсдэлийн сан 33.14 хувиар өссөн байна. Зээлийн чанар муудаж байгаатай холбоотойгоор ББСБ-ууд Засгийн газрын арилжааны үнэт цаасанд хөрөнгө оруулах нь нэмэгдсэн хэдий ч богино хугацаат хөрөнгө оруулалт нь нийт активын 0.28 хувьтай тэнцэж байна. ББСБ-уудын зээлийн өрийн үлдэгдэл 638.0 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын 4.79 хувьтай тэнцэж байх ба энэ нь өмнөх оноос 0.89 хувиар өссөн дүн байна. 2016 оноос зээлийн жигнэсэн дундаж хүү 0.63 хувиар буурч 3.37 хувь болсон нь банкны салбараас 1.8 хувиар өндөр үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын нийт хөрөнгийн 78.2 хувийг өөрийн хөрөнгө, 21.8 хувийг өр төлбөр бүрдүүлж байгаа нь өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулдаг онцлогтой холбоотой юм. ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн төвлөрлийг харвал 1.0 тэрбумаас доош хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 339 ББСБ нийт активын 32.94 хувийг, 1-2.4 тэрбум хүртэл хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 140 ББСБ, 2.5 тэрбумаас дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 55 ББСБ байгаа бөгөөд эдгээр 195 ББСБ нь нийт активын 67.06 хувийг бүрдүүлж байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2.5 тэрбум байхаар шинэчлэн тогтоож 2021 он хүртэл үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээ авч, хангалтыг хэрэгжүүлэн ажилласнаар 2017 онд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 154.8 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оноос 35.15 хувийн өсөлттэй гарчээ. Энэ өсөлтийн 111.5 тэрбум төгрөг буюу 72% нь үе шаттай нэмэгдүүлж байгаа ББСБ-ууд байгаа бол 43.3 тэрбум төгрөг буюу 28% нь шинээр тусгай зөвшөөрөл авсан ББСБ-ууд байна.

Нийт ББСБ-уудын өөрийн хөрөнгийн өгөөж 10%, активын өгөөж 7.6% байна. Нийт ББСБ-ын 84.6% буюу 452 ББСБ зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан бол үлдэх 82 ББСБ буюу 15.4% нь зохистой харьцааны зарим үзүүлэлтийг хангаагүй ажилласан байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР